



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

Засгийн газрын IX байр, Энхтайвны өргөн чөлөө 16а,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,
Цахим шуудан: mofa@mofa.gov.mn,
Цахим хуудас: www.mofa.gov.mn

2022.04.06 № 01/1100
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Танаас 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх асуулгын хариуг хүргүүлж байна.

1. Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн худалдан авалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд 3 хүртэл жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй 200.0 тэрбум төгрөгийн зээлийг ноолуурын салбарт, 70.0 тэрбум төгрөгийн зээлийг ноосны салбарт олгох, дахин санхүүжүүлэх. Дахин санхүүжилтэд зориулан олгох зээлийн хэмжээ Компанийн тухай хуульд заасан хамаарал бүхий этгээдэд 10.0 тэрбум төгрөгөөс хэтрэхгүй байх;

“Төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолд ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн салбарт 200.0 тэрбум төгрөгийн 1 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр олгохоор шийдвэрлэсэн.

Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор арилжааны 6 банктэй гэрээ байгуулан хамтран ажилласнаар ноолуурын салбарт 38 аж ахуйн нэгжид 94.8 тэрбум, ноосны салбарт 4 аж ахуйн нэгжид 3.2 тэрбум төгрөгийн зээл олгогдож, зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 7.65 хувиар тооцож, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас 2021 онд 3.2 тэрбум, 2022 оны эхний 3 сарын байдлаар 1.6 тэрбум төгрөгийг арилжааны банкнуудад шилжүүлээд байна.

Үндэсний үйлдвэрлэгчид 2021 онд нийт 2660 тн ноолуур бэлтгэснээс хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 38 аж ахуйн нэгж өөрийн хөрөнгө болон 94.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр 1064 тн ноолуур бэлтгэсэн.

Статистикийн мэдээгээр ноос, ноолуурын салбарын нийт экспорт 2021 онд 368.5 сая ам.доллар болж, 2020 онтой харьцуулахад 33 хувиар өссөний дотор самнасан ноолуур болон бэлэн бүтээгдэхүүний экспорт тус тус нэмэгдсэн байна. Зээлд хамрагдсан 42 аж ахуйн нэгж нь 3271 ажлын байрыг хадгалж, 41 ажлын байрыг шинээр бий болгосон зэрэг нь зээлийн үр дүнг эерэг байгааг харуулж байна.

00000556

Монгол Улсын Засгийн газраас 2022 онд ноолуур бэлтгэл, үйлдвэрлэлд 150.0 тэрбум төгрөг, ноос бэлтгэл, үйлдвэрлэлд 25.0 тэрбум, арьс шир бэлтгэл, үйлдвэрлэлд 15.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай, улсын төсвөөс 10.65 хувийн хүүгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр арилжааны банкны эх үүсвэрээр олгохоор шийдвэрлэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам болон Монгол банкны хооронд байгуулах 3 талт “Хөдөө аж ахуйн зээлийн хүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн гэрээ”, арилжааны банкнуудтай байгуулах “Зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-ний төслийг боловсруулан, оролцогч талуудаас санал авч, аж ахуйн нэгжүүдэд зээл олгох бэлтгэл ажлыг хангаад байна.

2. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор 2023 оноос угаасан ноолуурыг экспортлохгүй, самнаж боловсруулсан болон хялгасыг ялгасан ноолуурыг экспортлох, эдгээртэй холбоотой үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг баталж мөрдүүлэх;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, түүнийг даган гарсан “Техникийн зохицуулалт боловсруулах заавар”, бусад дүрэм, журамд нийцүүлэн боловсруулж, тус хуульд заасан үүргийн дагуу Дэлхийн худалдааны байгууллагад мэдэгдэж, гишүүн орнуудаас ямар нэгэн санал, шүүмж ирүүлээгүй болно.

Техникийн зохицуулалтын төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч, саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 01/3837 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Уг асуудлыг 2022 оны 05 дугаар сард хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.

3. Ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлоход нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөхтэй холбоотой асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс ноос, ноолуурын салбарыг үе шаттай хөгжүүлэх зорилгоор 2023 оноос ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг батлан мөрдүүлэх, угаасан ноолуурын экспортыг зогсоох, ноолуурыг бүрэн самнаж боловсруулах, дараагийн шатанд ээрэх, нэхэх үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа юм.

Ноос, ноолууран түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулах зорилгоор ээрэх, нэхэх үйлдвэрлэлийн зориулалт бүхий 30 нэр төрлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу урьдчилан гаргасан ба салбарын үйлдвэрүүдээс ээрэх, нэхэх үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа, үнэ, жагсаалтыг мэргэжлийн холбоодоор дамжуулан авч, импортлоход нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх асуудлыг судалж, холбогдох тооцоо судалгааг гаргаад байна.

4. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх;

Дотоодын үйлдвэр эрхлэгчдийг төрийн худалдан авалтаар дэмжих, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудтай холбох, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах зорилгоор “Эх оронч худалдан авалт- Үндэсний үйлдвэрлэл 2021” уламжлалт үзэсгэлэнг анх удаа цахим хэлбэрээр 2021 оны 4 дүгээр сарын 01-ээс 5 дугаар сарын 01-ний өдрүүдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийн газар болон Төрийн худалдан авах ажиллагааны газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, “Экспорт олон улсын худалдааны төв” ТББ-тай хамтран зохион байгуулсан ба 94 төрийн байгууллага, 232 үйлдвэр эрхлэгчид оролцсон ба төрийн худалдан авалтад хэрхэн оролцох, татвар, нийгмийн даатгал, оюуны өмч, бүтээгдэхүүнээ экспортод гаргах боломж зэрэг үйлдвэр эрхлэгчдэд нэн шаардлагатай сэдвүүдээр 21 удаагийн сургалт хийсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Ерөнхий гэрээ”-гээр худалдан авах бараа, үйлчилгээг тодорхойлж, цахим дэлгүүрт байршуулах, Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-д ноос, ноолууран нэхмэл, сүлжмэл, эсгий, эсгий бүтээгдэхүүнийг нэмэх саналыг Төрийн худалдан авах газарт хүргүүлээд байна. Мөн уг тогтоолын хавсралтад зарим бараа, бүтээгдэхүүнийг нэмэх зорилгоор “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж байна.

“Кашемир холдинг” ХХК нь Цагдаагийн ерөнхий газарт 8855 ширхэг, Дотоод хэргийн их сургуульд 250 ширхэг тэмээний ноосон дотортой хантааз, “Ашид нит” ХХК нь Цагдаагийн ерөнхий газар болон Дотоодын цэрэгт нийт 800,000 ширхэг малгай, ороолт, ноосон цамц, Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2,000 метр ноосон даавуу, “Гламор” ХХК нь Гаалийн ерөнхий газарт 400 ширхэг ноосон цамцыг тус тус үйлдвэрлэж нийлүүлсэн байна.

Засгийн газрын 2013 оны “Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай” 250 дугаар тогтоолын хүрээнд зээл авсан аж ахуйн нэгжүүдийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой асуудал шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд байгаа тул ноосон даавуу үйлдвэрлэж төрийн худалдан авах үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал байна.

A red official stamp with a signature in black ink. The stamp contains Mongolian text, including "МОНГОЛ" (Mongolia) and "З. МӨНДСАЙХАН" (Z. Mendsaikhan). The signature is written over the stamp.

З. МӨНДСАЙХАН